

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО
“АЛСЫН ХАРАА-2050”-Д ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ
ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТУСГАГДСАН БОДЛОГЫН ЗОРИЛТ,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ

2024.08.30-ны байдлаар

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод эрчим хүчний салбарын чиглэлээр тусгагдсан зорилт, үйл ажиллагааны 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн байдлаарх урьдчилсан гүйцэтгэл, үр дүнг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан аргачлалаар гүйцэтгэлийг тооцож хувиар илэрхийлэв.

“Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод Эрчим хүчний яамны хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан 2 зорилтын хүрээнд 10 арга хэмжээ байна.

Тус бодлогод тусгагдсан 10 арга хэмжээний **2024 оны эхний 8 сарын байдлаарх хэрэгжилтийн явц 75.47 хувьтай** байна.

Үйл ажиллагааны хэрэгжилт

№	Зорилт	Үйл ажиллагаа	Хэрэгжилт
1	2.5. Амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлж баталгаат хүнсээр хангана.	2.5.4.Орон сууцны халаалт, эрчим хүчний эх үүсвэрийг сэргээгдэх эрчим хүчээр хангана.	100%
2	4.2. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.	4.2.34.Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг хангах дулааны цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгөж, шинэ цахилгаан станц барьж дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортолно.	100%
3		4.2.35.Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн босоо болон хөндлөн гол тэнхлэгийн цахилгаан дамжуулах агаарын шугам барьж дэвшилтэт технологид суурилсан дэд бүтэц бүхий ухаалаг нэгдсэн систем байгуулна.	30%
4		4.2.36.Эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулгын эх үүсвэрийг барьж байгуулан импортын эрчим хүчний хараат байдлыг бууруулна.	100%
5		4.2.37.Сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан чадлыг 30 хувьд хүргэх, гадагш урсгалтай гол, мөрний урсцын 10 хувийг эрчим хүчний үйлдвэрлэл болон бусад хэрэгцээнд ашиглана.	100%
6		4.2.38.Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн орчин үеийн дэвшилтэт технологийг түшиглэн орон нутгийн дулаан хангамжид ашиглана.	50%
7		4.2.39.Хот, сум, суурин газрын дулаан хангамжийн чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор дулааны эх үүсвэр, дулааны шугам сүлжээний өргөтгөл шинэчлэл хийнэ.	76.5%

8		4.2.40.Зүүн хойд азийн орнуудтай хамтран азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээний санаачилгыг хэрэгжүүлнэ.	30%
9		4.2.41.Эрчим хүчний салбарт инновац, дэвшилтэт техник, ухаалаг технологийг нэвтрүүлж, санхүүгийн бие даасан, үр ашиг, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлнэ.	70%
10		4.2.42.Эх үүсвэрийн чадлын баланстэй уялдуулан нар, салхи, ус, биомасс, шингэн болон хийн түлш, газрын гүний дулаан, түлшний элемент, бусад шинэ эх үүсвэрийг ашиглана.	98.2%
Хэрэгжилтийн дундаж			75.47%

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

2024 оны 08 дугаар сарын 29-ний өдөр